

АЛТАЙ УЛСЫН «ЖАНГАР»-Т ХОЛБОГДОХ СОЁЛЫН УЛАМЖЛАЛЫН АСУУДАЛ

Dava Taya
 Inner Mongolia University
 Hoh-Hot, China

SEVERAL ISSUES RELATED WITH THE NAME OF EPIC JANGAR IN GORNO-ALTAI

Abstract: The article discusses the reason of varieties and respective meanings in name of Epic Jangar in Altai Republic, and argues how it should be written in Mongolian, and then the author comes out with his explanations about the word 'Jangar'.

Keywords: epic, Jangar, Altai people, Mongolian people.

Баатарлаг тууль “Жангар” бол монгол төрөл хэл ба түрэг төрлийн хэлийг сундалсан аман уламжлал мөн. Өнгөрсөнд зарим эрдэмтдээс түрэг төрөл хэлний “Жангар”-ын уламжлалыг дэмий сайн ойлгодоггүй болохоор “Жангар”-ыг зөвхөн монгол үндэстний тууль хэмээн үзэж, түүнийг монгол үндэстэн, жич түүн лүгээ холбоо бүхий умардын үндэстний түүхтэй холбон судалдаг байлаа. Үүнд олонхи эрдэмтдээс монгол хэлээр уламжлагдсан “Жангар”-ын материалд л суурилан, нэг хэсэг хүмүүс нь “Жангар”-ыг Хүннү улсын Шаньюй хаанаас Торгууд хаант улсын Аюухь хаан хүртэлх ямар нэгэн түүхэн хүнтэй холбож судалдаг байхад, нөгөө хэсэг хүмүүс нь “Тэр чигээрээ 14-17 дугаар зууны Монголын нийгэм, ялангуяа Ойрадын нийгмийн түүхийн үнэн бодтой тусгал” [Тэнгис, 2001, р. 20] гэх зэргээр ямар нэгэн цаг үеийн нийгэм түүхтэй холбох буюу эсэхүл “Жангар болон түүний баатарчууд түрүүн дөрвөн Ойрад, дундад дөрвөн Ойрад, сүүлийн дөрвөн Ойрад гурван адил бус түүхийн шат үеийн эл аймгийн хаад ноёдын түүхийн дүрийн тусгал мөн. Харин ямар нэгэн ганц хүний түүхийн дүрийн тусгал биш юм. Бодтойгоор хэлбэл, Тогоон тайш болон түүний хойчис Цоросын эл үеийн хаад ноёд бол Жангарын түүхийн дүр болох, Өрөгтөмөр болон түүний хойчис Хошуудын эл үеийн хаад ноёд бол Хонгорын түүхийн дүр болох, Амгалан тайш болон түүний хойчис Торгуудын эл үеийн хаад ноёд бол Алтан цээжийн түүхийн дүр болох. Тохурагуд (Торгууд) аймгийн феодал ноёд бол Миньян болон Бор магнай зэргийн баатарчуудын түүхийн дүр болно” [Монголжин Алтан-Оргил, 1996, р. 203] гэхчилэн олон түүхт хүний дүрийн нийлбэрээр үздэг. Энэ асуудалд зориулж миний бие “‘Жангар’-ын тууль газарзүй судлал – эртний монголчуудын газарзүйн үзэлтийн мөрдөл” [Даяа, 2014] гэх ном туурвиж, монгол хэлээр уламжлагдсан “Жангар”-ыг тууль газарзүйн хараанаас л үзэхэд түүний гол баатрыг түүхэн хүн мөн гэж үзэхэд бэрхтэй гэх санаагаа дэвшүүлсэн юм.

Олны мэдээжээр, монгол хэлтний туулийн олонхи нь “Уулын түүхийн дурсамжаасаа түүхийн зориг санаа өөд, түүхийн туулиасаа язгуур тууль зүг шилжсэн” [Таяа, 2014, р.17] байхад, түрэг хэлтний туулийн уламжлал нь харин түүхийг хүүрнэх буюу эсэхүл туулийг түүхчлэх хандаштай [坂井弘紀:《中央アジアの英雄叙事詩 語り伝わる歴史》, 東洋書店, 2002年] гэж олонхи хүмүүс үзэцгээдэг. Тэгвэл түрэг төрөл хэлээр уламжлагдсан “Жангар”-т түүний гол баатар нь түүхэн хүн мөн гэдгийг батлах баримт байдаг уу? гэх асуулт аяндаа тавигдана. Ийнхүү доор түрэг хэлний “Жангар”-ын хамгийн том уламжлалын орон болох Оросын холбооны Алтай улсын баатарлаг тууль “Жангар” жич түүнтэй ижил нэр бүхий уламжлалт соёлын үзэгдлийг сахиулсны нэр, сарын нэрийдэл, дууны төрлийн нэр, бүжгийн нэр жич туулийн нэр зэрэг таван талаар шинжлэхээр дамжуулж түрэг төрөл хэлтний “Жангар”, онцгойлон алтайчуудын эртний соёлын уламжлал дахь “Жангар” нь түүх лүгээ хэр зэрэг холбоотой байх жич түүний ирэл гарлын асуудлыг сүвэгчилье.

Сахиулсны нэр

Алтай улсын шидэт үлгэрт усан галвын дараа үүдэгч сахиулснаас нарт ертөнцөд томилсон хамаг анхны хоёр элчийн нэгийг нь нэрийг Жангар хэмээн домоглодог [Клешев, 2011, р. 93, 159]. Энэ тухай эрдэмтэн Вербицкий (Василий Иванович Вербицкий) (1827-1890)-н 1854 оны үеэр Алтай нутгаас тэмдэглээд 1893 онд хэвлүүлсэн “Алтайчууд” гэх номд нийтлүүлсэн домгуудын доторх “Бөөгийн үүсэл” гэх шидэт үлгэрт тэмдэглэснээр, усан галвын дараа үүдэгч сахиусан Өлихэн хүн амьтанд туслуулахаар тэнгэрийн орноос нарт ертөнцөд томилсон хоёр элчийн нэг нь Барилкс гэдэг байж нөгөө нь Жангар хэмээгч байв. Тэр хоёр бүр Эрлэг хаанаас бөө мөргөлийн эрдэм сурсан боловч Барилкс нь зөвхөн онгод оршуулахыг л сурч Жангар нь

харин ганц онгод дуудахыг л сурсан байжээ. Ийнхүү тэд хоёул хамтран бөөгийн эрдэм чадвараараа усан галавт автагдсан хүн амьтныг тусалж барсны дараа, үүдэгч сахиулсан Өлихэнөөс онгод оршуулах эрдэмтэй Барилксыг Эрлэгийн зарцаар томилоод, онгод дуудах чадвартай (эчнээ ертөнцтэй харилцах эрдэмтэй) Жангарыг нарт ертөнцөд үлдээж хамаг анхны бөө болгосон байв [Алтайские инородцы, 1893, pp. 126-128]. Энд Жангар гэдэг нь хүн төрөлхтний амь насыг аварсан сахиулсны нэг болох мөртөө хүн төрөлхтний шүтлэг бишрэлийн соёл – бөө мөргөлийг үүдэгч соёлын баатрын дүрээр илэрч буй. “Үг хэлний ялгарал” гэх нөгөө нэг шидэт үлгэрт хүн төрөлхтөн зарч (заргач – эшлэгч)-ийн ач тусаар ихэд үржиж өсөөд дараачийн усан галваас зайлахын төлөө 77 тулгууртай өндөр уул бүтээж тэр нь тэнгэрт тулах шахаад тэнгэрийн оронд сүрдүүлэл болоход, Жангараас тэнгэрсийн санааг урьдчилан мэдээд: “Та нар тэнгэр бурханы эсрэг их буруу юм хийж байна, би уул хийхэд оролцмооргүй байна” гэж хэлээд явдаг [Алтайские инородцы, 1893, pp. 126-128; Арефьев, 2002, p. 38; Клешев, 2011, p. 193, 159]. Энд Жангар нь тэнгэрийн санааг ард иргэдэд уламжлагчийн дүрээр илэрч байх мөртөө тэнгэрсийн санааг үнэнчээр мөрдөн дагагч болж буй. Эдгээрээс харахад алтайчуудын шидэт үлгэрт Жангар гэдэг нь үүдэгч сахиулснаас нарт ертөнцийн хүн амьтныг авруулахаар буулгасан элчийн нэг байж хожим нь үүдэгч сахиулсны томилолтоор хүний ертөнцөд үлдээд хамаг анхны бөө болсноор барахгүй нарт ертөнцийн хүмүүст тэнгэрийн санааг дамжуулагчаар оршиж байв. Иймээс алтайчуудад авч хэлбэл Жангар гэдэг нь нарт ертөнцийн түүхэн хүн бус, харин шидэт үлгэрийн ертөнц дэх анхны сахиулсны нэг байв.

Сарын нэрийдэл

Жилийн сүүл сар (12 дугаар сар) алтайчууд “Жангар сар (Янар ай)” гэдэг [Клешев, 2011, p. 93]. “Жангар сар” гэдэг нэрийдэл нь эртний сарын нэрийдлээр Алтай улсын музейн эд өлөг-т илэрснээр барахгүй одоо үеийн хуанлийн үзүүлэг-т хүртэл хэрэглэгдэж буй. Нөгөө талаар алтайчууд эрт дээр үеэс сарын нэрээр хүүхдэд нэр тавих уламжлалтай байж “Жангар сар (билгийн улирлын 12 дугаар сар)”-д төрсөн хүүхдэд байнга “Жангарай (Янараи)” гэх нэр өгөөд “Цагаан сар (Чаган ай)” (1 дүгээр сар)-д төрсөн хүүхдэд “Цагаан (Чаган)” буюу “Цагаандай (Чагандай)” гэдэг нэр өгөх уламжлалтай байв [Екеев, 2014, p. 295]. Энд гарч бүхий “Жангарай” гэх нэр нь Оросын Холбооны Алтай улс лугаа газарзүйн хувьд ойролцоо байх Монгол улсын Хөвсгөл аймгийн Галт сумаас тэмдэглэсэн “Богд ноён Жангарай”, чинагшид Дорнод аймгийн Матад сумаас тэмдэглэсэн “Богд ноён Жангарай”, Баянхонгор аймгийн Жаргалант сумаас тэмдэглэсэн “Богд Дэчин Жангарай” жич Финляндын монголч эрдэмтэн Г.И. Рамстедт 1909 оны сүүлчээр одоогийн Улаанбаатараас тэмдэглэсэн “Богд догшин Жангарай хаан” [Баясгалан, 2010] зэрэг Монгол улсын “Жангар”-ын бүлгийн гол баатрын нэрийн дуудлагатай ижилхэн байна. Нөгөө талаар алтайчуудын сахиулсны нэрээр сарын нэр болгосон явдал нь эртний ромчуудаас “Janus (Үүдний сахиулс)”, “Febris (Эрлэгийн орны сахиулс)”, “Mars (Дайчин сахиулс)” зэрэг сахиулсны нэрээр “нэгдүгээр сар”, “хоёрдугаар сар”, “гуравдугаар сар”-ыг тус тус нэрлээд одоохны Европ дахины сарын нэрийдэл үүссэн [傅嘉梁: 《关于拉丁语中十二个月份名称的由来》, 《历史教学问题》, 1984年05期]-тэй ижилхэн соёлын үзэгдэл байв. Ер нь сарын нэрийдлийг “Жангар” хэмээн нэрлэдэг уламжлалаас үзэхэд, алтай хэлний “Жангар” гэдэг үг нь баатарлаг туулиас улирч ирсэн бус, харин “Жангар” гэх сахиулсны нэр жич түүнд холбогдох шидэт үлгэрээс ирэлтэй байж мэднэ. Ийнхүү алтайчуудын Жангар гэдэг нь сүүлийн үеийн түүхэн баатарт холбогдох домог дурсамж бус, харин нэлээд эртнээс уламжлалтай соёлын үзэгдэл болохыг харуулж буй.

Дууны төрлийн нэр

Алтайн уламжлалт магтаал дууны нэгэн төрлийг “Жангар (Янар)” [Самыков, Самунов, Сартакова, 1984; Торобогошева, 2017; Ойношев, 2011] буюу “Жангар кожонг (Янар кожон)” гэж нэрлэдэг. Үүнд “кожон” гэдэг нь “алтайчуудын ардын дууны ерөнхий нэр мөн” [Демчинова, 2012]. Иймээс “Янар” буюу “Янар кожон” нь мөн ч “Жангарын дуу” гэх үг мөн. Алтайчуудын угсаатан зүйн ойлборт “Жангар” гэдэг үгийг “Жангар – зан үйлийн дуу, ямар нэгэн зан үйлийг гүйцээх үед үргэлж бүхэл дугариг буюу хагас дугариг хэлбэртэй зогсож дуулдаг” [Екеев, 2014, p. 433] гэх буюу “Жангар кожон – тахилга тайлгын зан үйлийн дуу” [Екеев, 2014, p. 433] хэмээн тайлбарлаж буй. Энэ тухай Алтай улсын ардын дуу судлаач М.А. Демчинова алтайчуудын ардын дууны доторх онцгой нэгэн төрөл бол даруй “Жангарын дуу (Янар кожон)” мөн. Тэр нь алтайчуудын эртний тахилга тайлгын зан үйлтэй холбогддог. Учир нь тус төрлийн дууг голдуу тахилга тайлгад оролцогсдоос Алтайн уул усны эзэд сахиулсад зориулж олноороо цуурай татуулан дуулдаг. Тус төрлийн дуунд хааяа хүний ертөнцийн амьдралын сайн сайхныг магтан дуулсан агуулгыг ч багтаадаг. Алтай нутагт буддын шашин дэлгэрч байх үед бурханд ч зориулан дуулж байсан [Демчинова, 2012, pp. 59-60] гэв. Энэ нь Халимаг буюу Шинжааны монголчууд “Жангар” хайлахаасаа өмнө эцэг тэнгэр, этүгэн эх, уул усны

ээд сахиулс, жич “Жангар”-ын сахиулсанд зориулж “Жангарын магтаал” дуу дуулдаг [Таяа, 2015, pp. 166-174]-тай ойролцоо байна. Гэтэл монголчуудын “Жангарын магтаал”-ын агуулга нь голдуу дууныхаа гарчигтайгаа адилхан Жангар баатар буюу Жангарын сахиулснаа магтан дуулахаар гол болгож байхад, Алтайн “Жангарын дуу”-ны гарчигт л “Жангар” гэх үг үлдэж, агуулгад нь харин Жангар гэх баатар (буюу сахиулс)-ын нэр нь гээгдэж эзэд сахиулсанд зориулсан магтаал дуу болсон байна. Энэ нь Монгол улсын дөрвөд, захчин жич Оросын холбооны халимаг зэрэг ястан, Дундад улсын Хөхнуур, Ганьсу гэх мэт газар орны “Жангарын магтаал” нь ч Жангар гэдэг баатар (буюу сахиулс)-ын магтаалаасаа салж морины магтаал буюу эсгий гэрийн магтаал тийш шилжсэнээрээ ижил байна [Таяа, 2015, p. 170]. Өөрөөр хэлбэл, тус хоёр газар орны дуу нь баатар (буюу сахиулс)-ын магтаалаас өөр юмны магтаал тийш улирч хувирсан талаараа адил байна. Үнэндээ алтайчуудад авч хэлбэл, Жангар гэдэг нь ганц түүхэн баатар буюу туулийн баатар бус, харин сахиулсны нэг (Алтайн аливаа эзэд сахиулсны дээдэс) болохоор Алтайн эзэд сахиулсанд зориулсан магтаал нь мөн ч сахиулс Жангарын магтаал болох ёстой.

Бүжгийн нэр

Алтайчуудын уул хайрхны тахилгын үед олноороо гар гараа барилцан бүтэн тойрог буюу хагас тойрог болж хүрээлэн бүжиглэдэг уламжлалт бүжгийг мөн “Янар (Жангар)” гэдэг. Тус бүжгийг бүжиглэхэд олноороо гар гараа барилцан хүрээ хэлбэртэй болдог болохоор “Күрөө Янар (Хүрээ Жангар)” ч гэдэг. Энэ тухай Алтайн үндэстний бүжиг судлаач А.И.Шинжинагаас алтайчууд “эрт дээр үеэс нэг нь нөгөөгийнхөө гарыг атгах буюу нэг нь нөгөөгийнхөө мөр дээр гараа тавиад ‘Жангарын дуу (Янар кожон)’-г дуулаад нааш цааш найгах, эсэхүл эргэн тойрч бүжиглэдэг уламжлалтай юм... ‘Хүрээ жангар (Күрөө Янар)’ бол алтайчуудын иймэрхүү уламжлалт бүжгийн соёлын нэг төрөл мөн. Тэр нь Эвенк үндэстний ёхор (ехорье), Якутын осаухай (осуохай), Буриадын ёхор (ехор)-той адилхан” [Шинжина, 2007, p. 159] гэсэн байна. Цаашид Алтайн баатарлаг тууль “Жангар” хийгээд ардын бүжиг “Жангар”-ын ялгаа зөрөөний тухай “Алтайн баатарлаг тууль ‘Жангар’ нь дуу ба хөгжмийн нийлбэр байхад ‘Хүрээ Жангар’ нь харин хөгжим ба бүжгийн нийлбэр мөн” [Шинжина, 2004, p. 159] гэснээс үзэхэд, алтайчуудын “Жангар” гэх ардын бүжиг хийгээд “Жангар” хэмээх баатарлаг тууль нь ижил нэгэн соёлын үзэгдлийн адил бус хоёр зүйлийн жүжиглэж тоглох хэлбэр байв. Үүнтэй ойролцоо Шинжаан Ойрадын жангарч нараас уул усны эзэд сахиулсан жич Жангарын сахиулсанд зориулж өөрийн бие цогцын хөдөлгөөнөөр баатарлаг тууль “Жангар”-ын товч агуулгыг дүрслэн үзүүлдэг уламжлалтай байв. Тухайлбал, Шинжааны Хежин сияны жангарч Пунсагаас “Жангарын бий (бүжиг)-н дуу”-г дуулж “Жангарын бий (бүжиг)”-г бүжиглэдэг [Таяа, 2015, p. 294]. Үүнээс үзэхэд, Алтайн ардын бүжиг “Жангар” нь Шинжааны жангарчдын бүжиглэдэг “Жангарын бий (бүжиг)”-тэй үүсэл гарлын талаар холбоотой байна. Алтай “Жангар” гэх бүжиг нь хэдийгээр “Жангарын дуу (Янар кожон)”-г дуулаад бүжиглэдэг боловч “Жангарын дуу”-ны агуулга нь “Жангар” хэмээх туулиасаа салсантай адилхан “Жангар” хэмээх бүжигт нь ч баатарлаг тууль “Жангар”-ын агуулга нь гээгдэж голдуу уул хайрхны эзэд сахиулсанд зориулсан иргэний бүжгийн нэр болсон байна. Үнэндээ тус бүжиг нь “Жангарын дуу (Янар кожон)”-тайгаа ижилхэн, Жангарын сахиулсан жич уул усны эзэд сахиулсанд зориулсан тахилга тайлгын бүжиг болох ёстой. Иймээс алтайчуудын “Жангар” хэмээх бүжиг нь эртний шүтлэг бишрэлийн ажиллагаатай холбоо бүхий зан үйлийн уламжлал буюу иргэний уламжлалт бүжгийн соёл байв.

Туулийн нэр

Алтай улсын цорын ганц мөчлөг туулийн нэр буюу түүний гол баатрын нэрийг Жангар гэдэг. Тус туулийн аман уламжлалд холбогдох домог яриа нь 17 дугаар зуунд холбогддог [Малчиев Ч., Житель села Малый-Яломан Онгудайского района. Информацио дал в 1974 // Шинжин, 2006, p. 56] боловч тус туулийн тухай эрдэм шинжилгээний мэдээлэл нь эрдэмтэн Л.П. Потаповын 20-р зууны дөчөөд оны “Алтайчуудын баатарлаг тууль” хэмээх өгүүллээс эхлээд [Потапов, 1949, pp. 125-128] тусгайлсан судлал нь эрдэмтэн С.С. Суразаковын “Жангар” ба алтайчуудын баатарлаг тууль” гэх өгүүллээр эхлэлээ болгосон юм [Суразаков, 1974, p. 74]. Онцгойлон эрдэмтэн Т.Б.Шинжинээс 1977-1980 оны хооронд Алтайн алдарт туульч Николай Кокурович Ялатов хайллагын дуу бичлэг хийж, хожим нь “Жангар – Алтайн баатарлаг тууль” гэх гарчгаар гурван боть болгон 1997, 2002, 2004 онд тус тус Алтай улсад хэвлэгдэв [Янар / Янар: Алтайский героический эпос, 1997; Янар / Янар: Алтайский героический эпос, 2002; Янар / Янар: Алтайский героический эпос, 2004]. Тус туулийн нэр нь хэдийгээр Жангар хэмээх баатрын нэрээр нэрлэсэн боловч бүхий л туулийн агуулга нь дэлхий ертөнц сая үүсч бүрэлдэх үед газар ээж (эх газрын сахиулс)-ээс төрсөн баатар Жангар, түүний үр ач нарын хоёр үеийн хойчис жич түүний бусад баатруудаас Алтай нутгаа хамгаалсан үлгэрийг ярьдаг. Даруй “Жангар” гэдэг тууль нь ертөнцийг үүдэгч баатар Жангарын үлгэр байснаасаа, сүүлд нь түүний хойчис буюу түүнд харьяалагдах бусад баатарчуудын үйл ажиллагааг хүүрнэсэн

том мөчлөг туулийн нэр болсон байна. Гэхдээ Алтайн настайчууд Алтайн бүх тууль нь бүр “Жангар”-аас үүсэж хөгжсөн гэдэг [Суразаков, 1974, р. 74]. Онцгойлон эрдэмтэн Л.П. Потопова 1942 онд “Жангар”-ыг багтаасан Алтайн олон тууль хайлдаг алдарт туульч Н.Улагашев (1861-1946)-ыг сурвалжлахад тэрбээр: “Жангар бол газар тэнгэр бүрэлдэх үүссэн Алтайн хамаг анхны тууль мөн” [Потапов, 1949, pp. 125-128] гэсэн байв. Эрдэмтэн С.С. Суразаков (1925-1980) ч 1965 онд алдарт туульч Н.Улагашевтай уулзахад тэрбээр “Алтайн олонхи туулийн баатар нь бүр Жангарын баатрын хүүхдийн үлгэр мөн” [Суразаков, 1974, р. 74] гэх үгийг нэмж ярьсан байв. Эдгээр настайчууд буюу туульчдын яриа нь баатарлаг тууль “Жангар”-ын гол баатар ертөнцийн үүслийн цаг буюу “сахиулсны цаг үе”-тэй холбох гэсэн санаа гарч байна. Цаашид Монгол үндэстний “Жангар”-т Жангараас дээрх хэдэн үеийн өвөг дээдсийн нэрийг дурдах буюу заримынх нь бодтой үлгэрийг ярьдаг байхад, Алтай “Жангар”-т харин гол баатар Жангарыг “Цагаан тайга аавтай, Цагаан далай ээжтэй” [Жангар / Янгар: Алтайский героический эпос, 1997] хэмээн хүний ертөнц дэх өвөг дээдэс буюу удам угсааг нь тоочин ярьдаггүй явдал нь түүний ертөнцийг үүдэн бүтээгч сахиулс буюу баатрын тусгал байж мэднэ. Мөн Алтайн баатарлаг тууль “Жангар”-ын гарчгийг “Үүдэгч баатар Жангар” [Шинжин, 2006; Шинжин, 1997] гэдэг нь ч үүнтэй холбоотой юм. Ийнхүү Алтайн туульчдаас баатарлаг тууль “Жангар”-аа сахиулс өөд хандуулах чиглэлтэй байж харин түүхэн хүн зүг холбох бодол сэтгэлгээ дэмий харагдахгүй байна.

Багцаалбал, алтай буюу монгол хэлний “Жангар” хэмээх баатарлаг тууль нь голдуу туулийн гол баатар болох “Жангар”-ын нэрээр нэрлэгдэх төдийгүй түүний баатарлаг үйл ажиллагаа, үр хойчис буюу түүний бусад баатрынх нь баатарлаг үйл ажиллагааг хүүрнэдэг аварга том мөчлөг тууль болох мөртөө тэр нь дууны төрөл буюу бүжгийн нэртэй холбогдсоноороо ижил талтай боловч Алтайн “Жангар” нь харин сахиулсны нэр ба сарын нэртэй холбогддоогоороо өвөрмөц байна. Онцгойлон Алтайн аман уламжлалд Жангар гэдэг нэрийг шидэт үлгэрийн ертөнцтэй холбох хандаштай байдгаараа зарим эрдэмтдийн ярьдаг түрэг хэлтний туулийн уламжлалтай ялгаатайгаар барахгүй монголчуудын “Жангар”-ын уламжлалтай ч зөрөөтэй байна. Өөрөөр хэлбэл, монголчуудаас “Жангар”-ыг туулийн баатраар хүүрнэх хандлагатай байхад алтайчууд харин түүнийг шидэт үлгэр буюу аливаа соёлын үзэгдлийн эхлэл өөд чиглүүлж буй. Даруй Монголд “Жангар” гэдэг нь голдуу Жангар хэмээх баатарт холбогдох аман уламжлал байхад, Алтайд харин баатар Жангарын үлгэрээс гадна Жангар хэмээх сахиулсанд холбогдох аман уламжлал буюу түүний нэрд холбогдох соёлын үзэгдэл ч болсон байна. Ийнхүү алтайчуудын “Жангар”-ын тухай ойлголт нь юунд монголчуудаас ялгаатай болсон бэ? Жангар хэмээх баатар жич түүнд холбогдох аман уламжлал нь чухам юунаас ирэлтэй вэ? гэх асуулт тавигдаж байна. Энэ тухай хоёр зүйлийн төсөөлөл гаргаж болно. Нэгд, Жангар бол үнэхээр уугал Алтайн соёлын сахиулсны нэрээс ирэлтэй байж, тэр нь шидэт үлгэр ба сарын нэрийдэлт үлдсэнээр барахгүй, түүний ач гавьяаны магтаал дуулал нь ардын дуу буюу баатарлаг тууль болж, түүнд зориулсан тайллага, тахилгын үйл ажиллагаа нь бүжгийн соёл болсон магадгүй. Хоёрт, Жангар хэмээх узуур эртний түүхэн баатрын магтаал дуулаас түүнд холбогдох дуу, тууль, бүжиг үүсч, түүний тухай хүмүүсийн шүтлэг бишрэлийн ажиллагааны хөгжил хувирал нь түүнийг сахиулсанчлах чиглэлийг буй болгож, цаашид Алтайн шидэт үлгэр буюу сарын нэрийдлийг нөлөөлсөн магадгүй. Өөрөөр хэлбэл, Жангар гэдэг нь нэг бол анх эхэндээ бодтой түүхээс ирэлтэй домгийн хүн байсан бололтой байж, үгүй бол эртний шүтлэг бишрэлээс гаралтай сахиулсны нэр буюу шидэт үлгэрийн баатар байсан боломж буй. Гэхдээ тус асуудлыг зөвхөн алтайчууд буюу эсэхүл монголчуудын соёлын үзэгдлээр нэг л дор шийдвэрлэж дийлэх зүйл бус болохоор хойшид нэн өргөн хараа зогсоцоос улам нэг алхам судалж шинжлэх явдал бачим шаардагдаж байна. Юу ч гэсэн “Жангар” нь шидэт үлгэрээс хөгжиж ирсэн ч тэр, түүхээс дурсамжаас хувирч ирсэн ч тэр, одоохны байдалд түрэг төрлийн хэлтний нэг болох Алтай улсын “Жангар”-аас ямар нэгэн түүхийн бодтой хүний үлгэр мөн гэдгийг батлах баримт байхгүй гэгчийг энд онцлон дурдъя. Цаашид монгол баатарлаг тууль “Жангар”-ын гол баатар Жангарыг шууд монгол үндэстэн жич түүн лүгээ холбоотой умардын үндэстний түүхэн хүнтэй холбож ярих нь төдий утга агуулгагүй явдал болох буюу эсэхүл тус асуудлыг шийдвэрлэх цаг хугацаа болоогүй гэдгийг чухалчилъя.

Ном зүй

坂井弘紀:《中央アジアの英雄叙事詩 語り伝わる歴史》, 東洋書店, 2002年。

傅嘉梁:《关于拉丁语中十二个月份名称的由来》,《历史教学问题》, 1984年05期

Алтайские инородцы: Сб. этногр. ст. и исслед. алт. миссионера, протоиерея В. И. Вербицкого / Под ред. А. А. Ивановского. Горно-Алтайск, 1893. 270 с.

Арефьев В. Мифы и шаманизм Алтая. Барнаул, 2002.

- Баясгалан Т. Жангар туулийн хэв шинжийн харьцуулсан судалгаа // *Bibliotheca Oiratca XVI*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2010.
- Демчинова М.А. Собрание и изучение Алтайских народных песен // *Филология и человек*. Барнаул, 2012. №1.
- Екеев Н.В. Алтайцы: этническая история, традиционная культура, современное развитие. Горно-Алтайск: БНУ РА, 2014. 463 с.
- Клешев В.А. Народная религия Алтайцев: вчера, сегодня. Горно-Алтайск, 2011. 246 с.
- Монголжин Алтан-Оргил. Жангарын шарын дөрвөн төр. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, 1996.
- Ойношев П. Эне бештин Жангары. Горно-Алтайск, 2011.
- Потапов Л.П. Героический эпос алтайцев // *Советская этнография*. Москва, 1949. № 1.
- Самыков Б., Самунов А., Сартакова С. Бирлик Жангар (Общая песня): Книга-кассета. Горно-Алтайск, 1984.
- Суразаков С.С. Калмыцкий «Джангар» и героический эпос алтайцев // *Проблемы алтаистики и монголоведения: мат-лы Всесоюз. конф., г. Элиста, 17-19 мая 1972 г. Элиста, 1974. Вып. 1.*
- Таяа Д. «Жангар»-ын тууль газарзүй судлал-эртний монголчуудын газарзүйн үзэлтийн мөрдал. Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2014.
- Таяа Д. «Жангар» уламжлах зан үйлийн судлал. Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2015.
- Таяа Д. Жангарчийн судлал. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2015.
- Торобогошева Күпей. Юрекетен чыккан жангарлар. Горно-Алтайск, 2017.
- Тэнгис. Монгол Баатарын тууль ба эртний тал нутгийн боловсон. Бээжин: Үндэстэний хэвлэлийн хороо, 2001.
- Шинжин И.Б. Сказитель Н.К. Ялатов и «Бессмертный Янгар-Богатырь». Горно-Алтайск: Горно-Алтайская республиканская типография, 1997.
- Шинжин И.Б. Сквозь века и поколения сказителей. Горно-Алтайск, 2006.
- Шинжина А.И. Национальный театр танца «Алтам». Эскизы и костюмы. Горно-Алтайск, 2007.
- Шинжина А.И. Основы Алтайского танца, Горно-Алтайск, 2004.
- Жангар / Янгар: Алтайский героический эпос. Т.1 / Сказитель Н.К. Ялатов. Вступ. ст. и коммент. И.Б. Шинжина. Горно-Алтайск: Ак-чечек, 1997. 319с.
- Жангар / Янгар: Алтайский героический эпос. Т.2 / Народный сказитель РА Н.К. Ялатов. Горно-Алтайск: ГУ кн. изд-во «Юч-Сюмер – Белуха» РА, 2002. 320с.
- Жангар / Янгар: Алтайский героический эпос. Т.3 / Народный сказитель РА Н.К. Ялатов. Горно-Алтайск: Ак-чечек, 2004. 351с.